

**ЗТХ-ИЙН САЙДЫН 2017 ОНЫ САНХҮҮГИЙН НЭГДСЭН ТАЙЛАНГИЙН  
АУДИТААР ИЛЭРСЭН АЛДАА, ЗӨРЧИЛ ТҮҮНИЙГ ШИЙДВЭРЛЭХ  
ТАЛААР АВЧ ХЭРЭГЖҮҮЛСЭН АРГА ХЭМЖЭЭ**

**2018.12.10**

Зам, тээврийн хөгжлийн сайдын 2017 оны санхүүгийн нэгдсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитад төсөвт байгууллага төсвийн шууд захирагч 2, хөрөнгө оруулалтын зардлын данс 1, төсвийн төвлөрүүлэн захирагч 1, улсын төсөвт үйлдвэрийн газар 1, төрийн өмчит компани, үйлдвэрийн газар 45, төсөл, хөтөлбөр 13 нийт 63 байгууллага хамрагдсан байна.

Зам, тээврийн хөгжлийн сайдын эрхлэх асуудлын хүрээний дээрхи 63 байгууллагаас 3 төсөл хөтөлбөрт аудит хийгээгүй, 14 байгууллага түүвэрт хамрагдаж, 1 байгууллагад итгэл үзүүлэн 45 байгууллагад санал дүгнэлт гаргасан байна.

Санал дүгнэлт гарсан 45 байгууллагаас “Зөрчилгүй санал дүгнэлт” авсан 42 байгууллага, “Хязгаарлалттай санал дүгнэлт” авсан 3 байгууллага байна. Сөрөг болон санал дүгнэлт өгөхөөс татгалзсан байгууллага байхгүй. /өмнөх онд Монголын төмөр зам ТӨХК-д санал дүгнэлт өгөхөөс татгалзсан/

Хязгаарлалттай санал дүгнэлтийг “Монголын төмөр зам” ТӨХК, “Авто замын тоног төхөөрөмжийн түрээс” ТӨХК, “Булган АЗЗА” ТӨХК-ий санхүүгийн тайланд өгсөн байна.

Аудитаар “Зөрчилгүй санал дүгнэлт” авсан боловч материаллаг бус 115 алдаа зөрчил илэрсэн байна. Үүнийг хүснэгтээр нэгтгэн харуулбал:

**Алдаа, зөрчлийн нэгтгэл**

№	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Алдаа, зөрчил		Үүнээс					
				Зөвлөмж		Албан шаардлага		Төлбөрийн акт	
		тоо	дүн	тоо	дүн	тоо	дүн	тоо	дүн
1	Төсвийн ерөнхийлөн захирагч								
2	ЗТХЯ хөрөнгө оруулалт	<b>5</b>	<b>1,933.0</b>	<b>4</b>	<b>1,644.1</b>			<b>1</b>	<b>288.9</b>
1	ЗТХЯамны аппарат	2	40.9	2	40.9				
2	алт тэрэгний хөдөлгөөн зохицуулах төв	2	4.9	2	40.9				
	<b>Төсвийн шууд захирагчийн дүн</b>	<b>4</b>	<b>45.8</b>	<b>4</b>	<b>45.8</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>0</b>
1	<b>“ИНЕГ” агентлаг ТТЗ</b>	<b>22</b>	<b>5,082.8</b>	<b>11</b>	<b>1,019.4</b>	<b>10</b>	<b>4,061.0</b>	<b>1.0</b>	<b>2.4</b>
1	ИНЕГ-ын үйлдвэрлэл нисэхийн хөдөлгөөний алба ТӨҮГ	8	3,553.6	11	1,019.4	10.0	4,061.0	1.0	2.4
2	МИАТ ТӨХК	5	2,297.0	5	2,297.0				
3	“Монголын төмөр зам” ТӨХК	5	9,764.2	4	489.6	1.0	9,274.6		
4	Зам, тээврийн хөгжлийн төв ТӨҮГ	2	7.9	1		1.0	7.9		
5	Авто тээврийн үндэсний төв ТӨҮГ	4	76.2	4	76.2				
6	“Авто замын тоног төхөөрөмжийн түрээс” ТӨХК	4	170.0	3	84.4	1.0	85.6		
7	Авто зам арчлалтын 13 ТӨХК	52	1,401.9	47	1,252.9	3.0	146.9	2.0	2.1
8	Далайн захиргаа УТҮГ	3	5.7	2	4.7			1.0	1.0
	<b>Төрийн өмчит үйлдвэрийн дүн</b>	<b>83</b>	<b>17,276.5</b>	<b>70</b>	<b>4,760.4</b>	<b>8.0</b>	<b>11,604.2</b>	<b>5.0</b>	<b>911.9</b>
1	Авто замын сан	-	-	-	-	-	-	-	-
2	Авто замын норм нормативын сан	-	-	-	-	-	-	-	-
3	Төсөл хөтөлбөр	1	184.9	1	184.9				
	<b>Төсөл сангийн дүн</b>	<b>1</b>	<b>184.9</b>	<b>1</b>	<b>184.9</b>				
	<b>ДҮН</b>	<b>115</b>	<b>24,523.0</b>	<b>90</b>	<b>7,654.6</b>	<b>18</b>	<b>15,665.2</b>	<b>7</b>	<b>1,203.2</b>

Үндэсний аудитын газраас хийсэн аудитаар 24,522.9 сая төгрөгийн 115 алдаа зөрчил илэрснээс 1,203.2 сая төгрөгийн алдаа зөрчилд 7 төлбөрийн акт тогтоож, 15,665.2 сая

төгрөгийн зөрчилд 18 албан шаардлага өгч, 7,654.5 сая төгрөгийн алдаа зөрчилд 90 зөвлөмжийг холбогдох албан тушаалтанд өгсөн байна.

**1. Төлбөрийн акт:** ҮАГ-аас хийсэн Санхүүгийн тайлангийн аудитаар 1,203.2 сая төгрөгийн 8 төлбөрийн акт тогтоосон ба төлбөрийн актын биелэлтийг байгууллага тус бүрээр хүснэгтээр харуулбал:

### Төлбөрийн актын биелэлт

/сая. төгрөгөөр/

№	Байгууллагын нэр	Төлбөрийн акт		Хэрэгжилт		
		Тоо	Дүн	тоо	дүн	хувь
1	ЗТХЯ-ны хөрөнгө оруулалт	1	288.9	1	288.9	100%
2	ИНЕГын Сэргээн засах сувилал	1	2.4	1	2.4	100%
3	ИНЕГ-ын үйлдвэрлэл, нисэх хөдөлгөөний алба	2	908.8	2	732.5	80.6%
4	Авто замын засвар арчлалт ТӨХК	2	2.1	2	1.1	52.4%
5	Далайн захиргаа УТҮГ	1	1.0	1	1.1	100%
<b>НИЙТ ДҮН</b>		<b>7</b>	<b>1,203.2</b>	<b>5</b>	<b>1,024.8</b>	<b>85.2%</b>

Нийт 1,203.2 сая төгрөгийн 7 төлбөрийн актын 75.7 хувийг ИНЕГ-т ногдуулсан бол 24 хувийг ЗТХЯ-ны хөрөнгө оруулалтын дансаар гарсан зөрчилд ногдуулсан байна.

Аудитын тогтоосон төлбөрийн акт 85.2 хувьтай хэрэгжиж 1,024.8 сая төгрөгийг Үндэсний аудитын газрын Төрийн сангийн дансанд төвлөрүүлсэн байна.

**2. Албан шаардлага:** Аудитаар нийт 15,665.2 сая төгрөгийн 18 албан шаардлага өгсөн ба албан шаардлагын биелэлтийг байгууллага тус бүрээр харуулбал:

/сая.төгрөгөөр/

№	Байгууллагын нэр	Албан шаардлага		Хэрэгжилт		
		Тоо	Дүн		дүн	хувь
1	ИНЕГ агентлаг ТТЗ	10	4,061.0	7	3,248.8	80
2	ИНЕГ-ын үйлдвэрлэл, нисэх хөдөлгөөний алба	2	2,089.2	2	1,253.5	70
3	“Монголын төмөр зам” ТӨХК	1	9,274.6	1	552.6	46
4	Зам, тээврийн хөгжлийн төв ТӨҮГ	1	7.9	1	7.9	100
5	Авто замын тоног төхөөрөмжийн түрээс ТӨХК	1	85.6	0	0	0
6	“Булган АЗЗА” ТӨХК	1	144.4	1	114.4	79.2
7	Авто замын засвар арчлалтын компани	2	2.5	2	2.5	100
<b>НИЙТ ДҮН</b>		<b>18</b>	<b>15,665.2</b>	<b>13</b>	<b>5,179.7</b>	<b>72.9</b>

Зам, тээврийн хөгжлийн сайдын 2017 оны Санхүүгийн нэгдсэн тайлангийн аудитаар тогтоосон 15,665.2 сая төгрөгийн алдаа зөрчилийг арилгах хугацаатай 18 албан шаардлагыг дээрхи 7 байгууллагат хүргүүлснээс “Монголын төмөр зам” ТӨХК 9,274.6 сая төгрөгийн зөрчилд тогтоосон албан шаардлага нийт үнийн дүнгийн 59.2 хувийг эзлэж байна.

“Монголын төмөр зам” ТӨХК-иас Төрийн өмчийн хороо /ТӨХ/-ны /хуучин нэрээр/ хүсэлтээр 3 хүний гадаад томилолтын зардлыг төлсөнтэй холбоотой 2012 онд үүссэн авлага байсан бөгөөд ЗГ-ын 2016 оны тогтоолоор ТӨХ-г татан буулгаж Сангийн яаманд шилжүүлсэн, дараа ТӨБЗГ болж өөрчлөн зохион байгуулагдсан бөгөөд балансанд энэ өглөг байхгүй тул төлөх боломжгүй гэх хариуг ТӨБЗГ-с тус компанид ирүүлсэн байх тул 51.4 сая төгрөгийн

авлага нь найдваргүй болох эрсдэлтэй тооцоо нийлсэн актгүйгээр бүртгэгдсэн бол сургалтын төлбөртэй холбоотой үүссэн 3.3 сая төгрөгийн авлагаас 2.3 сая төгрөгийг барагдуулж үлдэгдэл 958.0 сая төгрөг хуваарийн дагуу төлөгдөхөөр байна.

Харин Төмөр замын хөдлөх бүрэлдэхүүнийг нэмэгдүүлэхтэй холбоотой үүссэн 35.7 сая ам.доллар буюу 86.629.5 сая төгрөгийн зээлийн хуримтлагдсан хүүгийн 9,219.9 сая төгрөгийг төлөөгүй тооцоо нийлж баталгаажуулаагүй, дамжуулан зээлдүүлэх гэрээ байгуулаагүй гэх үндэслэлээр тогтоосон албан шаардлага байна.

Энэхүү шаардлага нь Төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, ЗТХЯ, “МТЗ” ТӨХК-ий хооронд дамжуулан зээлдүүлэх гуравласан гэрээг байгуулсны үндсэн дээр биелэгдэх юм. Энэ асуудал эцэслэгдээгүй боловч хэлэлцээр хийгдэж байгаа гэсэн үндэслэлээр 40%-ийн хэрэгжилтээр авсан.

Харин Авто замын тоног төхөөрөмжийн түрээс ТӨХК нь татан буугдсан тул албан шаардлага, зөвлөмжийн биелэлт гаргаж ирүүлээгүй.

#### Аудитын зөвлөмжийн биелэлт

№	Байгууллагын нэр	Зөвлөмж тоо	Хэрэгжилтийн байдал			
			Хэрэгжсэн	Хэрэгжих шатанд	Хэрэгжээгүй	Хувь
1	Зам, тээврийн хөгжлийн сайдын нэгдсэн тайлан					
2	ЗТХЯ хөрөнгө оруулалт	4	3	1		87.5%
3	ЗТХЯамны аппарат	3	2	1		83.3%
4	Галт тэрэгний хөдөлгөөн зохицуулах төв	2	2			100%
5	“ИНЕГ” агентлаг ТТЗ	11	8	3		86.4%
6	ИНЕГ-ын үйлдвэрлэл нисэхийн хөдөлгөөний алба ТӨҮГ	4	3	1		87.5%
7	МИАТ ТӨХК	5	2	3		70%
8	“Монголын төмөр зам” ТӨХК	4	3	1		87.5%
9	Зам, тээврийн хөгжлийн төв ТӨҮГ	1	1			100%
10	Авто тээврийн үндэсний төв ТӨҮГ	4	4			100%
11	“Авто замын тоног төхөөрөмжийн түрээс” ТӨХК	3			3	0
12	Авто зам арчлалтын 13 ТӨХК	47	36	8	3	84%
13	Далайн захиргаа УТҮГ	2	2			100%
14	Төсөл хөтөлбөр	1	1			100%
<b>ДҮН</b>		<b>90.0</b>	<b>67.0</b>	<b>17.0</b>	<b>6.0</b>	<b>83.9%</b>

Аудитаар өгөгдсөн нийт 90 зөвлөмжийн 67 зөвлөмж буюу 74.4 хувь нь бүрэн хэрэгжиж, 17 зөвлөмж буюу 18.8 хувь нь хэрэгжих шатандаа, 6 зөвлөмж буюу 6.7 хувь нь огт хэрэгжээгүй байна.

2018 оны 12 дугаар сарын 17-ны байдлаар актын хэрэгжилт 85.2 хувь, албан шаардлагын хэрэгжилт 72.9 хувь, зөвлөмж 83.9 хувийн хэрэгжилттэй байна.

Төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгдсэн тайланд нэгтгэгдсэн харьяа байгууллагуудын санхүүгийн тайлангийн аудитаар 52,166.3 сая төгрөгийн алдаа зөрчил илэрснээс 29,576.3 сая төгрөгийн зөрчлийг залруулж, 914.4 сая төгрөгийн 6 төлбөрийн акт, 15,665.2 сая төгрөгт 18 албан шаардлага, 6,010.4 сая төгрөгийн зөрчлийг давтан гаргахгүй байх талаар холбогдох албан тушаалтанд 86 зөвлөмж ирүүлснээс зөрчил арилгалт дундажаар 78.6 хувьтай байна. Үүнээс “Авто замын тоног төхөөрөмжийн түрээс” ТӨХК нь

2018 оны 1 –р улиралд татан буугдсан тул зөвлөмжийн биелэлтийг гаргаж ирүүлээгүй 0 хувийн хэрэгжилттэй гарсан.

Санхүүгийн нэгдсэн аудитаар илэрсэн зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх, акт, албан шаардлага зөвлөмжийн биелэлтийг хангаж ажиллах анхаарч Зам, тээврийн хөгжлийн сайдын 2018 оны 5 дугаар сарын 10-ны өдрийн “Аудитын зөвлөмжийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” 98 дугаар тушаал гарч Зам, тээврийн хөгжлийн сайдын 2017 оны санхүүгийн нэгдсэн тайлан төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж биелэлтийг тайлагнаж ажиллахыг холбогдох албан тушаал, төсөв захирагч нарт даалгасан.

Мөн Зам, тээврийн хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн даргын 2018 оны 07 дугаар сарын 04-ний өдрийн 207 дугаар тушаал гарч “Аудитын зөвлөмжийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө”-г баталж шуурхай үр дүнтэй зохион байгуулан тухай бүр явцыг тайлагнан биелэлтийг ирүүлэхийг яамны бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн дарга, захирал нарт даалгасан. Төлөвлөгөөний хэрэгжилтийг сар улирлаар гарган нэгтгэж ажилласан.

Цаашид анхаарч ажиллах, шийдвэрлэх гол асуудлыг Сайдын дотоод аудитын нэгжээс зөвлөмж болгоход: Санхүү, нягтлан бодох бүртгэлийн чиглэлээр:

1. Авто замын засвар арчлалтын компаниудад салбарын онцлогт тохирсон Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг” боловсруулан батлуулж мөрдүүлэх.
2. Төмөр замын хөдлөх бүрэлдэхүүнийг нэмэгдүүлэх төслийн хүрээнд нийлэгдсэн хөрөнгийн зээлийн “Дамжуулан зээлдүүлэх гэрээ”-г яаралтай зохион байгуулж үндсэн зээл, зээлийн хүүг төлөх график төлөвлөгөөг батлуулан хэрэгжүүлэх.
3. Харилцагч бэлтгэн нийлүүлэгч байгууллагатай цаг тухай бүр тооцоо нийлж, тооцооны үлдэгдэл/авлага, өглөг/-ийг хянаж баталгуулж байх.
4. Өр авлага гаргахгүй байх, олон жил болсон, авлага өглөгийг шийдвэрлэх, найдваргүй авлагын нөөц үүсгэх тухай Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт /СТОУС/-д нийцүүлэх, бодлогын баримт бичигт тусгаж шийдвэрлэх.
5. Компаний дүрэмд заасан хөрөнгө, улсын бүртгэлийн гэрчилгээнд туссан дүрмийн сангийн хөрөнгийн дүн хоорондоо зөрүүтэй байгаад анхаарч залруулах арга хэмжээг авах.
6. Анхан шатны баримтын бүрдэл дутуу ажил гүйлгээ гаргахгүй байх, анхан шатны баримтгүй гүйлгээг бүртгэлд тайланд тусгахгүй байхад анхаарах гэсэн жил бүр давтагдаж байдаг гол алдаа, зөрчлүүдийг залруулан дахин давтан гаргахгүй ажиллахад бүх шатны санхүүгийн ажилтнууд анхаарч ажиллах шаардлагатай.

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ, ДОТООД АУДИТЫН ГАЗАР